

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**


2020 оны 03 дугаар сарын 23

Багануур дүүрэг

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ							
Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:							
18	1.10. “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	1.10.1. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг эрчимжүүлнэ.	БҮТП ОНӨТҮГ, ДБҮҮХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	98	
		1. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын хувьд “Мон-Энержи Консалт” ХХК нь цахилгааны горим ачааллын тооцоог Эрчим хүчний яамны “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иар гүйцэтгүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/16 дугаартай албан бичгээр хүлээн авсан. Ингэснээр цахилгаан хангамжийн төлөвлөлтийн зураг төсөл бэлэн болсон. Зураг төслийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авах асуудлыг газрын дарга Эрчим хүчний яамны сайдтай биечлэн уулзаж шийдвэрлэсэн. “Мон-Энержи Консалт” ХХК нь Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн батлагдсан төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01 дугаартай актаар “Барилга хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. “Мон-Энержи Консалт” ХХК-ийн Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл магадлангаар хянагдаж дулаан хангамж, мэдээлэл холбооны ажлын зураг баталгаажсан ба одоогийн байдлаар гүйцэтгэгч байгууллага нь Паркийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийг экспертээр баталгаажуулан ерөнхий дүгнэлт гаргуулахаар бэлтгэж байна.					
		2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, “Санни трейд” ХХК-ийн гүйцэтгэсэн “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлагдсан. “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ Паркийн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.				100	

		<p>3. 2020 оны Нийслэл болон Улсын төсвөөс Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд ямар нэгэн хөрөнгө санхүүжилт олгогдоогүй. Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн өндөр хүчдэлийн 4,2км агаарын шугам эхний ээлжинд байгуулах чухал шаардлагатай. Энэхүү төслийн саналыг хөрөнгө оруулагч нарт санал болгосноор “МЕСЕС” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр БҮТП-ийн Хуулийн зөвлөх С.Отгонбаатар, “МЕСЕС” ХХК-ийн удирдлага болон “Мон-энержи Консалт” ХХК-ийн Бизнес хөгжлийн захиралтай хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Тус компани нь Паркийн цахилгаан хангамжийн трассыг ашиглан өөрийн үйлдвэрийн цахилгаан хангамжийг байгуулах ба хоёр талын хамтын ажиллагааг дээрхи гэрээгээр баталгаажуулсан болно. Эхний ээлжинд шаардлагатай бүх зардлыг тус компани гаргаж 4,2км цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамыг байгуулж манай Паркийн эзэмшилд бүрэн шилжүүлэн өгөх юм. Паркийн зүгээс дээрх зардлын 50%-ийг Нийслэлийн төсвийн тодотголоор оруулах санал тавьж, дүүргийн болон нийслэлийн Засаг дарга нарын хэмжээнд шийдвэрлүүлсэн. БҮТП нь уг гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд “МЕСЕС” ХХК нь цахилгаан хангамжийн трасс, төлөвлөлтийг гүйцэтгэгч байгууллага мөн дүүргийн газрын алба болон хангагч байгууллагуудтай зөвшилцөн ерөнхий схемийг боловсруулсан. Одоогийн байдлаар шаардлагатай техникийн нөхцөлийг гаргуулахаар Барилга хот байгуулалтын яамнаас Эрчим хүчний Сайдад 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/685 дугаартай албан бичгээр хандаад байна.</p>	40	
		<p>4. Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилгын зураг төслийг гүйцэтгэгч “Нутаг консалтинг” ХХК нь барилгын инженерийн шугам сүлжээний зураг төслийг техникийн нөхцөлийн дагуу боловсруулан, дүүргийн хангагч байгууллагатай зөвшилцсөний дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан ба зураг төслийг баталгаажуулан магадлангаар хянуулахаар бэлтгэж байна.</p>	90	
		Дундаж хувь	82	

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

Lajavit

Б.НОМИНЗУЛ